

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/178/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@ audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Төлбөрийн акт.....	19
Байхгүй	19
4.3 Албан шаардлага	19
4.4 Зөвлөмж	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ А.ГАЛИЯ ТАНАА

᠒᠐᠒᠒.᠐᠒.᠒1 № 83
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

ХХҮГ-Дүгнэлт-2.18-ТА

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



ХХҮГ-Дүгнэлт-2.18-ТА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,027,417.76</u>	<u>5,244,128.76</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг		
31140	Касс арилжааны банк		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах		
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах		
33	АВЛАГА	-	102,711.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		102,711.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
335	Бусад авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага		
3352	Хувь хүмүүсээс авах авлага		
35	БАРАА МАТЕРИАЛ	5,027,417.76	5,141,417.76
354	Хангамжийн материал	5,027,417.76	5,141,417.76
35410	Бичиг хэргийн материал		
35420	Аж ахуйн материал	3,839,599.95	3,953,599.95
35470	Бусад хангамжийн материал	1,187,817.81	1,187,817.81
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>222,581,298.49</u>	<u>197,870,458.65</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	222,581,298.49	197,870,458.65
392	Биет хөрөнгө	201,213,298.71	173,213,792.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	102,689,570.00	102,689,570.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(5,249,860.68)	(7,146,353.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	117,644,160.00	117,644,160.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(117,644,160.00)	(117,644,160.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	311,230,336.65	170,664,577.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	(219,994,829.61)	(103,082,347.65)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,964,807.65	31,292,697.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	(49,304,875.30)	(22,082,501.43)
39214	Бусад үндсэн хөрөнгө		
39215	Хуримтлагдсан элэгдэл		
39217	Ном	878,150.00	878,150.00
393	Биет бус хөрөнгө	21,367,999.78	24,656,666.64
39301	Програм хангамж	18,840,445.00	15,080,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(10,042,445.22)	(2,993,333.36)
39303	Бусад биет бус хөрөнгө	12,570,000.00	12,570,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>227,608,716.25</u>	<u>203,114,587.41</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>1,062,104.00</u>
41225	Бусад гадаад эх үүсвэрээс		
413	Өглөг	-	1,062,104.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		1,062,104.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>227,608,716.25</u>	<u>202,052,483.41</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	227,608,716.25	202,052,483.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	366,556,926.98	366,556,926.98
51101	Өмч: - төрийн	366,556,926.98	366,556,926.98
51102	- хувийн		
512	Хуримтлагдсан үр дүн	(402,573,657.79)	(428,129,890.63)
51210	Өмнөх үеийн үр дүн	(470,078,334.21)	(402,573,657.79)
51220	Тайлант үеийн үр дүн	67,504,676.42	(25,556,232.84)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	263,625,447.06	263,625,447.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>227,608,716.25</u>	<u>203,114,587.41</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	784,898,589.00	709,556,666.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	784,898,589.00	709,556,666.40
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	763,898,589.00	690,441,666.40
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	676,188,900.00	679,612,000.00
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	-
131005	Хөрөнгийн санхүүжилт	87,709,689.00	10,829,666.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,000,000.00	19,115,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,000,000.00	16,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,115,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	717,393,912.58	734,886,482.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	717,393,912.58	734,886,482.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	695,410,412.58	702,246,282.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	535,212,139.56	526,291,993.00
210101	Үндсэн цалин	446,200,774.72	382,917,023.00
210102	Нэмэгдэл	79,735,564.84	124,873,270.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,275,800.00	18,501,700.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,565,460.44	73,680,000.00
210201	Тэтгэврийн даатгал	57,260,460.44	53,071,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,576,400.00	5,152,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,061,000.00	4,121,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	515,400.00	1,030,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,152,200.00	10,304,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,624,900.00	36,649,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,824,900.00	1,849,000.00
210304	Байрны түрээс	34,800,000.00	34,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,962,350.00	23,366,900.00
210401	Бичиг хэрэг	10,698,400.00	8,247,450.00
210402	Тээвэр, шатахуун	7,559,900.00	6,017,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,092,000.00	4,189,550.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,612,050.00	4,912,200.00
2105	Нормативт зардал	-	1,067,000.00
210502	Хоол, хүнс	-	1,067,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,601,350.00	1,443,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,601,350.00	1,443,400.00
210604	Урсгал засвар		
2107	Томилолт, зочны зардал	3,003,900.00	1,294,100.00
210702	Дотоод албан томилолт	3,003,900.00	1,294,100.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,412,000.00	2,570,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,250,000.00	1,250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	321,700.00	321,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,700.00	128,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	39,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	672,000.00	830,800.00
210807	Газрын төлбөр		
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,028,312.58	35,883,089.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	829,000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,199,312.58	35,883,089.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,983,500.00	32,640,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,983,500.00	32,640,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,002,000.00	31,855,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	981,500.00	785,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт,	-	-

	шилжүүлэг		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
213304	Хөрөнгийн		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		
213404	Хөрөнгийн		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж		
223001	Бусад хөрөнгө		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	67,504,676.42	(25,329,816.43)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	226,416.41
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		226,416.41
225002	Найдваргүй авлагын алдагдал		
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(226,416.41)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	67,504,676.42	(25,556,232.84)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	366,556,926.98	263,625,447.06	(402,573,657.79)	227,608,716.25
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	366,556,926.98	263,625,447.06	(402,573,657.79)	227,608,716.25
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C07	Тайлант үеийн үр дүн				-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	366,556,926.98	263,625,447.06	(402,573,657.79)	227,608,716.25
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	366,556,926.98	263,625,447.06	(402,573,657.79)	227,608,716.25
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	366,556,926.98	263,625,447.06	(402,573,657.79)	227,608,716.25
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D08	Тайлант үеийн үр дүн			(25,556,232.84)	(25,556,232.84)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	366,556,926.98	263,625,447.06	(428,129,890.63)	202,052,483.41

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>625,656,060.00</u>	<u>698,727,000.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	625,656,060.00	698,727,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	581,347,000.00	679,612,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	581,347,000.00	679,612,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,309,060.00	19,115,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	532,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,652,060.00	16,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	125,000.00	3,115,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>625,476,060.00</u>	<u>698,158,000.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	625,476,060.00	698,158,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	622,466,060.00	665,517,800.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	453,786,500.00	525,332,600.00
210101	Үндсэн цалин	354,065,000.00	381,957,630.00
210102	Нэмэгдэл	84,137,900.00	124,873,270.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,583,600.00	18,501,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,935,700.00	73,680,000.00
210201	Тэтгэврийн даатгал	51,036,400.00	53,071,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,474,800.00	5,152,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,579,800.00	4,121,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	894,900.00	1,030,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,949,800.00	10,304,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,923,400.00	36,649,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,123,400.00	1,849,000.00
210304	Байрны түрээс	34,800,000.00	34,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,212,600.00	23,509,300.00
210401	Бичиг хэрэг	15,550,000.00	8,287,100.00
210402	Тээвэр, шатахуун	12,364,500.00	6,017,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,052,500.00	4,123,400.00
210404	Ном, хэвлэл		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,245,600.00	5,081,100.00
2105	Нормативт зардал	1,284,000.00	1,067,000.00
210502	Хоол, хүнс	1,284,000.00	1,067,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,820,100.00	1,443,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,223,100.00	1,443,000.00
210604	Урсгал засвар	597,000.00	

2107	Томилолт, зочны зардал	14,566,760.00	1,294,100.00
210702	Дотоод албан томилолт	14,566,760.00	1,294,100.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,962,000.00	2,542,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	800,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	321,700.00	321,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,700.00	128,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	39,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	672,000.00	802,800.00
210807	Газрын төлбөр		
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,975,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	375,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,600,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,010,000.00	32,640,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,010,000.00	32,640,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		31,855,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,010,000.00	785,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>180,000.00</u>	<u>569,000.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
140002	Улсын төсвөөс олгосон зээл		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	180,000.00	569,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	180,000.00	569,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	180,000.00	569,000.00
220001	Барилга байгууламж		
223001	Бусад хөрөнгө		
224001	Стратегийн нөөц хөрөнгө		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	180,000.00	569,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(180,000.00)</u>	<u>(569,000.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	679,612,000.00	679,612,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	679,612,000.00	679,612,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	646,971,800.00	646,971,800.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	524,222,600.00	524,222,600.00
210101	Үндсэн цалин	396,775,500.00	380,847,630.00
210102	Нэмэгдэл	111,863,500.00	124,873,270.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,583,600.00	18,501,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,680,000.00	73,680,000.00
210201	Тэтгэврийн даатгал	53,071,100.00	53,071,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,152,200.00	5,152,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,121,800.00	4,121,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,030,400.00	1,030,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,304,500.00	10,304,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,649,000.00	36,649,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,849,000.00	1,849,000.00
210304	Байрны түрээс	34,800,000.00	34,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,429,300.00	8,429,300.00
210401	Бичиг хэрэг	2,482,100.00	2,482,100.00
210402	Тээвэр, шатахуун	2,417,700.00	2,417,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,403,400.00	1,403,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,126,100.00	2,126,100.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	-	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,443,000.00	1,443,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,443,000.00	1,443,000.00
210604	Урсгал засвар		
2107	Томилолт, зочны зардал	203,100.00	203,100.00
210702	Дотоод албан томилолт	203,100.00	203,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,344,800.00	2,344,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,250,000.00	1,250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	321,700.00	321,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,700.00	128,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	39,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	604,800.00	604,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-

210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,640,200.00	32,640,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,640,200.00	32,640,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,855,000.00	31,855,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	785,200.00	785,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	679,612,000.00	679,612,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	679,612,000.00	679,612,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	679,612,000.00	679,612,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	45	45
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	36	36
620003	Үйлчлэх ажилтан	8	8
620004	Гэрээт ажилтан		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	45	45
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	37	37
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,000,000.00	19,115,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21,000,000.00	19,115,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,000,000.00	19,115,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	1,110,000.00
210101	Үндсэн цалин		1,110,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,777,000.00	15,649,000.00
210401	Бичиг хэрэг	10,518,000.00	6,374,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,905,000.00	3,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	441,000.00	2,720,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	913,000.00	2,955,000.00

2105	Нормативт зардал	-	1,067,000.00
210502	Хоол, хүнс		1,067,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,644,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,644,000.00	
2107	Томилолт, зочны зардал	2,750,000.00	1,091,000.00
210702	Дотоод албан томилолт	2,750,000.00	1,091,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	198,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		198,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	829,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	829,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	21,000,000.00	19,115,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,000,000.00	19,115,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,000,000.00	16,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,115,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 01/29 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын зорилго нь нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн иргэдэд түргэн шурхай, чирэгдэлгүй хүргэхэд оршино. Үйл ажиллагаа нь Нийгмийн халамжийн хууль тогтоомж, ХНХЯамны бодлого, ХХҮЕГ-ын чиг үүргийг үндэс болгон олон нийтэд шударга, хүртэмжтэй мэргэжлийн түвшинд хүргэхийн зэрэгцээ нийгмийн халамжийн салбарт төрийн тусламж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай өрх, иргэн руу чиглэсэн байгууллага юм.

Тайлант онд тус газар нь “Хөдөлмөр, эрхлэлтийг дамжих, нийгмийн халамжийн үйлчилгээний мэдээллийн нэгдсэн системийн хэвийн найдвартай ажиллагааг хангах” гэсэн зорилтын дор ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ХХҮГ-т дотоод аудитор ажилладаггүй, тус газарт 2021 онд ХХҮЕГ-ын Мониторинг аудитын газар болон аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 717.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 7.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24.5 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага		102.70	102.70
Бараа материал	5,027.40	5,141.40	114.00
Үндсэн хөрөнгө	222,581.30	197,870.50	(24,710.80)
Нийт хөрөнгө	227,608.70	203,114.60	(24,494.10)
Өр төлбөр	-	1,062.10	1,062.10
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	227,608.70	202,052.50	(25,556.20)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	227,608.70	203,114.60	(24,494.10)

Мөнгөн хөрөнгө дансанд үлдэгдэлгүй, авлага данс оны эхэнд үлдэгдэлгүй, оны эцэст 0.1 сая төгрөгийн ажиллагсадтай холбоотой үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5.1 сая төгрөг болж 0.1 төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ. Тайлант онд 20.3 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 20.2 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна. Үнэ төлбөргүй бараа материал хүлээн аваагүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 196.4 сая төгрөг болж 24.5 сая төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 582 тоот тогтоолоор ашиглалтын хугацаа дууссан 185.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, программыг акталж данснаас хассан нь нөлөөлсөн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 0.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, ХХҮЕГ-аас 10.1 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, 1.1 сая төгрөгийн үлдэх өртөгтэй тоног төхөөрөмж шилжүүлэн авч данс бүртгэлд тусгасан байна.

Акталсан 185.8 сая төгрөгийн хөрөнгийг ХХҮГ-ын 2021 оны А/23 тоот тушаалаар батлагдсан Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрээр устгалд оруулж баримтжуулсан байна.

Өр төлбөр данс оны эхэнд өглөггүй, оны эцэст 1.1 сая төгрөгийн 1 ажилтанд олгогдоогүй цалингийн өглөгтэй гарсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өөрчлөлтгүй байна.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 709.5 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 75.3 сая төгрөгөөр буюу 9.6 хувиар бурсан үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө, нэмэлт санхүүжилтийн орлогууд байна. Энэ нь хөрөнгийн санхүүжилтээр хүлээн авсан хөрөнгийн дүн материаллаг хэмжээний өөрчлөлттэй буурсантай холбоотой.

Нийт зардал өмнөх оноос 17.4 сая төгрөгөөр буюу 2.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, эд хогшил, томилолтын зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар тайлант онд өөрчлөлт гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2021 оны анх батлагдсан төсөв 647.8 сая төгрөг ба тодотгосон төсөв 679.6 сая төгрөг байна.

Тодотголоор анх баталсан төсвийг 31.8 сая төгрөгөөр буюу тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж зардлыг нэмж батлан бусад зардлыг хэвээр нь баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 679.6 сая төгрөгийн төсөв баталж эх үүсвэрийг улсын төсөөс бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 679.6 сая төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 679.6 төгрөг зарцуулж төсвийн гүйцэтгэл 100.0 хувьтай байна.

Тус газрын батлагдсан төсөвт орон тооны хязгаарыг 45 хүнээр баталснаас гүйцэтгэлээр 45 орон тоогоор ажилласан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр арга хэмжээ, батлагдсан төсөв гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Арга хэмжээ	Нэршил	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	71902	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	646,971.8	646,971.8	0.0
2		80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	32,640.2	32,640.2	0.0
Нийт дүн				679,612.0	679,612.0	0.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 1 хөтөлбөр, 1 төсөл арга хэмжээний зардалд нийгмийн халамжийн сангаас 16.0 сая, цахим тендерийн орлогоос 3.1 сая төгрөгийн, нийтдээ 19.1 сая төгрөгийг бүрдүүлж зарцуулсан байна.

Үүнд: 15.6 сая төгрөгийг хангамж, бараа материалын зардалд, 1.1 сая төгрөгийг хоолны зардалд, 1.1 сая төгрөгийг томилолтын зардалд, 0.2 сая төгрөгийг мэдээлэл технологийн үйлчилгээний зардлуудад тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын бэлтгэж ирүүлсэн 2021 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал ороогүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай цалингийн зардалд 524.2 сая төгрөг, НДШ-ийн зардалд 73.7 сая төгрөг, тогтмол зардалд 36.6 сая төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 31.9 сая төгрөг нийтдээ 666.4 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэл нийт 679.6 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлын дүн 666.4 сая төгрөгийг хасахад 13.2 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 1.3 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа ба 2021 онд төсвөөс хэмнэлт гаргаж ажиллаагүй тул Засгийн газрын 2021 оны

Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын хэрэгжилт бүрэн хангагдаагүй гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар нь 2021 онд нийт 652.0 мянган төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 81 мэдээллийг ил тод байршуулж, 38 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шилэн дансанд тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс 46 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах, Шилэн дансанд заавал байршуулах мэдээллийг бүрэн байршуулах талаар зөвлөмж өгөгдснийг биелэлтийг ирүүлсэн боловч өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц онц асуудал байхгүй боловч санхүүгийн тайлангийн аудитыг түүврийн аргаар эрсдэлд тооцож үзсэн тул гүйцэтгэлийн шалгалтаар төсвийн зарцуулалтыг бүрэн үзэх, шилэн дансанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроохгүй оруулж байхыг хянах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 10.9 сая төгрөгийн алдааг залруулж, 1.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар акталсан хөрөнгийг данснаас хасах бичилт хийхдээ давхардуулан хассан дараах алдааг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

Санхүүгийн байдлын тайлан, Үр дүнгийн тайлан, үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд 5.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 0.5 сая төгрөгийн тавилга эд хогшлыг илүү, 0.2 сая төгрөгийн программын нийтдээ 6.4 сая төгрөгийг давхардуулан хассан, хуримтлагдсан элэгдэл данснаас 4.5 сая төгрөгийн данснаас хасалтыг зөрүүтэй тайлагнасан нийтдээ 10.7 сая төгрөгийн гүйлгээг залруулав.

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар 1.3 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1.Тайлант онд Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн 10 хувь 1.3 сая төгрөгийг хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалт, болон Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

2. Тайлант онд 2021 онд нийт 652.0 мянган төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 81 мэдээллийг хугцаанда байршуулж, 38 мэдээллийг хугацаа хоцроож байршуулан өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 4.1.4-т "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх", 5.1.4-т "мэдээллийг тогтмол шинэчилж байх", 6.1-д "энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "энэ хуулийн

3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажллах талаар зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Байхгүй

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	6	12.0	4	10.7			2	1.3		